



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар

0703

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх хяналт тавих журам”-ын 11.5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авахаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжийн төслийн материалыг холбогдох журмын дагуу 1.4, 5.9 дүгээр зүйлд заасан шалгуур хангаж буй эсэх болон ирүүлсэн материалын иж бүрдлийг шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхбаяр Жижиг дунд үйлдвэр, хөнгөн үйлдвэр, хоршоо,
ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд: Ж.Шинэ-Уянга Захиргаа аж ахуйн албаны дарга

Б.Дэлгэрмандах Тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн

2. Албан үүргийн дагуу олж авсан мэдээллийн нууцыг хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглахгүй байх, төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан сахиж, ажиллахыг үүрэг болгосугай.

3. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авахаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн төслийн материалыг журмын дагуу иж бүрдлийг үнэн зөв хийж мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Мөнхбаяр)-д даалгасугай.



ДАРГА ~~Ж.Мөнхбаяр~~ Б.МӨНХЖАРГАЛ

000001009